

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ БҮГД
НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН СОЛОНГОС АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоёр орны хоорондын найрамдал, хамтын ажиллагааны харилцааг цаашид бэхжүүлэн хөгжүүлэх, тус хоёр орны иргэдийн харилцан зорчиход тус дөхөм үзүүлэх, зорчих журмыг боловсронгуй болгох зорилгоор энэ Хэлэлцээрийг байгуулахаар шийдвэрлэж, дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

ЕРӨНХИЙ ЗААЛТ

Нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд харъяалах улсын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр паспортаар энэ Хэлэлцээрт заасан нөхцөлийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орж, гарч, дамжин өнгөрч, түр хугацаагаар байж болно.

Хоёрдугаар зүйл

Энэ Хэлэлцээрт дурдсан паспорт нь:

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэдийн хувьд
 - дипломат паспорт
 - албан паспорт,
 - энгийн гадаад паспорт,
 - гадаад паспорт (хувийн хэргээр зорчигчдод олгох),
 - БНМАУ-д буцах үнэмлэх байна.
2. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын иргэдийн хувьд:
 - дипломат паспорт,
 - албан паспорт,
 - паспорт (албан хэргээр зорчигчдод олгох),
 - паспорт (хувийн хэргээр зорчигчдод олгох).
 - гадаадад байнга оршин суугаа БНАСАУ-ын иргэдэд олгох иргэний паспорт
 - далайчдын үнэмлэх байна.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа гадаадын иргэдийг бүртгэх, оршин суух, зорчих, дамжин өнгөрөх зэрэг холбогдох хууль тогтоомжийг сахин биелүүлэх үүрэгтэй.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих өөрийн иргэдэд очоод бүртгүүлэх, оршин суух, зорчих тухай үндсэн журам, түүнчлэн гаалийн болон валютын хууль, дүрмийг

таниулж байна. Энэ зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд дээр дурдсан хууль дүрмийг харилцан мэдээлж, солилцож байна.

АЛБАН ХЭРГЭЭР ЗОРЧИХ

Дөрөвдүгээр зүйл

Харъяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суудаг бөгөөд албан хэргээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд болон тэдэнтэй адил харъяалал бүхий гэр бүлийн хүмүүс хүчин төгөлдөр паспортаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр орж, гарч, дамжин өнгөрч, түр хугацаагаар байж болно.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа улсын визтэй бол хүчин төгөлдөр паспортаар харъяат улсынхаа нутаг дэвсгэрт ганцаараа буюу хамтаараа албан хэргээр зорчиж болно.

Зургадугаар зүйл

Гуравдахь улсад байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын виз болон харъяат улсынхаа эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр паспортаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт албан хэргээр зорчиж болно.

ЖУУЛЧНААР ЗОРЧИХ

Долдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч Талуудын жуулчны байгууллагуулын хоорондын тохиролцсоны дагуу олгосон жуулчлалын баримт бичигтэй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр хүчин төгөлдөр паспортаар хамтаараа буюу ганцаараа жуулчилж болно.

2. Жуулчлалын нөхцөл болон жуулчлалын баримт бичгийн загварыг Хэлэлцэн тохирогч Талуудын жуулчны байгууллагууд тодорхойлно.

Жуулчлалын баримт бичгийн хүчин төгөлдөр байх хугацаа нь паспортын хүчин төгөллөр байх хугацаанаас хэтэрч болохгүй.

Наймдугаар зүйл

Жуулчны хэсгийн бүрэлдэхүүнд орж Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ирсэн бөгөөд хүндэтгэн үзэх ямар нэг шалтгаанаар хэсгээсээ хоцорсон Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын жуулчны байгууллагын зөвшөөрөлтэйгээр аялалаа үргэлжлүүлэх буюу хууль дүрэмд нь заасан журмын дагуу түүний нутаг дэвсгэрээс гарч болно.

ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгосон урилгын гэрчилгээ буюу зорчихыг зөвшөөрсөн

баримт бичигтэй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын виз бүхий хүчин төгөлдөр паспортаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа төрөл садныдаа хувийн хэргээр зорчиж болно.

Урилгын гэрчилгээ буюу зорчихыг зөвшөөрсөн баримт бичиг нь тэдгээрийг олгосон өдрөөс эхлэн нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

Аравдугаар зүйл

Гурав дахь улсад байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын виз бүхий хүчин төгөлдөр паспорттай бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хувийн хэргээр зорчиж болно.

Арван нэгдүгээр зүйл

Хувийн хэргээр зорчин яваа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд улсын хил нэвтэрсэн өдрөөс эхлэн тооцогдох хүчин төгөлдөр паспортад заасан визийн хугацаанд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байж болно.

Тэдний визийн хугацааг гагцхүү Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын бичгээр өгсөн зөвшөөрөлтэйгээр сунгаж болно.

БАЙНГА ОРШИН СУУХААР НЭВТРЭН ОРОХ

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд хүчин төгөлдөр паспорт болон хүлээн авагч улсын визтэй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суухаар орж болно.

ДАМЖИН ӨНГӨРӨХӨӨР ЗОРЧИХ

Арван гуравдугаар зүйл

Харъяат улсынхаа нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд:

1. албан хэргээр гуравдахь улсад яваа бол очих улсын нэрийг зааж бичсэн буюу тэр улсын виз бүхий хүчин төгөлдөр паспортаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрийг түүний визгүйгээр дамжин өнгөрч болно.

2. жуулчлах зорилгоор гуравдахь улсад яваа бол очих улсын нэрийг зааж бичсэн буюу тэр улсын виз бүхий хүчин төгөлдөр паспорт болон жуулчлалын баримт бичгээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрийг түүний визгүйгээр дамжин өнгөрч болно.

ГУРАВДАХЬ УЛСАД ЗОРЧИХ, ГУРАВДАХЬ УЛСААС ИРЭХ

Арван дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд харъяат улсынхаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын зөвшөөрөлтэйгээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын виз бүхий хүчин төгөлдөр паспортаар гуравдахь улсад зорчиж болно.

Арван тавдугаар зүйл

Гуравдахь улсад байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын виз бүхий хүчин төгөлдөр паспорт болон харъяалах улсынхаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын зөвшөөрөлтэйгээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хувийн хэргээр зорчиж болно.

ХҮҮХЭД ЗОРЧИХ

Арван зургадугаар зүйл

Насанд хүрээгүй хүүхэд өөрт нь олгосон хүчин төгөлдөр паспорт буюу эсвэл түүнийг дагуулж яваа эцэг эх, бусад хүний хүчин төгөлдөр паспортад бичигдсэн буюу хавсаргасан бол энэ Хэлэлцээрийн дагуу зорчиж болно.

БУСАД ЗААЛТ

Арван долдугаар зүйл

Энэ Хэлэлцээрт заагдаагүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын визтэйгээр түүний нутаг дэвсгэрт зорчиж болно.

Арван наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын иргэд энэ Хэлэлцээрийн дагуу зорчихдоо олон улсын зорчигчид явах замын хилийн нээлттэй боомтуудаар нэвтэрч болно.

Арван есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийн хүчин төгөлдөр паспортыг бүртгэх, виз олгох, хугацааг сунгах, паспортаа үрэгдүүлснээ мэдэгдсэний магадлагаа олгохдоо татвар, хураамж авахгүй.

Хорьдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд хүчин төгөлдөр байгаа паспорт, урилгын гэрчилгээний загваруудыг харилцан солилцох бөгөөд тэдгээрийг өөрчилсөн буюу шинэчилсэн тохиолдолд энэ тухайгаа 30 хоногоос хэтрүүлэлгүйгээр харилцан мэдэгдэж загварыг нь өгч байна.

Хорин нэгдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт паспортаа үрэгдүүлсэн Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой. Эрх бүхий байгууллага нь паспортаа үрэгдүүлсэн тухай мэдэгдсэнийг баталсан магадлагааг тухайн иргэнд олгож байна.

Тэр иргэний харъяалах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар үрэгдсэн паспортын оронд шинэ паспорт олгоно. Шинэ паспортаар гарах явдлыг паспорт үрэгдсэн тэр улсын дүрмээр зохицуулна.

Хорин хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд энэ Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шаардлагатай үед харилцан мэдээлж, зөвлөлдөж байна.

Хорин гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд харилцан тохиролцсоноор энэ Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хорин дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах буюу тэднийг нутаг дэвсгэртээ байлгах хугацааг богиносгох эрхтэй.

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт түр байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэдийн байх хугацааг богиносгосон тухайгаа тэднийг харъяалах улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт мэдэгдэнэ.

Хорин тавдугаар зүйл

Онцгой тохиолдолд (гоц халдварт өвчин, байгалийн гамшиг гэх мэт) Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэн орохыг түр хязгаарлаж болно.

Хэлэлцэн тохирогч Талууд нутаг дэвсгэртээ нэвтрэн орохыг хязгаарласан тухай болон түүнийг хүчингүй болгосон тухай зохих шийдвэр гаргаснаас хойш 24 цагаас хэтрүүлэлгүйгээр харилцан мэдээлж байна.

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

Хорин зургадугаар зүйл

1. Энэ Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн хууль тогтоомжийн дагуу батлагдах бөгөөд түүнийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Талдаа харилцан мэдэгдсэнээс хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэ Хэлэлцээрийг тодорхой бус хугацаагаар байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь энэ Хэлэлцээрийн үйлчилгээг зогсоох саналтай байгаагаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй бол Хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь энэ Хэлэлцээрийн үйлчилгээг зогсоох саналтай байгаагаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 60 хоногийн дараа Хэлэлцээр хүчингүй болно.

Хорин долдугаар зүйл

Энэ Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газрын хооронд үүний өмнө тохирсон тус хоёр орны иргэд харилцан зорчих тухай баримт бичгүүд хүчингүй болно.

Хорин наймдугаар зүйл

Энэ Хэлэлцээрт 1986 оны арваннэгдүгээр сарын 14-ний өдөр Пхеньян хотноо гарын үсэг зурж монгол, солонгос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд нь адил хүчинтэй байна.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН
СОЛОНГОС АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг